



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 08 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$7,175.6 сая

Мөнгөн дүн тайлантуулж хугацааны эцэст 7,175.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.1%-иар буюу 215.5 сая ам.доллараар өссөн. Үүнд экспорт 873.1 сая ам.доллараар өссөн ч импорт 657.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.2% буюу 4,390.2 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 15.1% буюу 1,082.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 24.7%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 4.9%-иар тус тус өсчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$23.0 сая

Мөнгөн дүн 2014 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -23.0 сая ам.долларт хүрч, тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 98.5%-иар буюу 1,530.7 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 32.3%-иар өссөн, импорт 15.4%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$183.5 сая

Валютаар төлбөр тооцог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 183.5 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 1,407.5 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 30.3%-иар өссөн, импорт 15.1%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.631 (Түршилт тооцоо)

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлантуулж хугацааны эцэст 1.631-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.9%-иар өслөө.


Экспортын үнийн индекс 3.2%-иар буурсан боловч импортын үнийн индекс түүнээс өндөр хувиар буюу 18.6%-иар буурсан нь гадаад худалдааны нөхцөлийн индекс ийнхүү өсөхөд нөлөөлжээ.

Импортын үнийн индекс өнгөрсөн оны мөн үеэс буурахад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, барилгын материал, нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 8 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	7,175.6	6,960.1	7,531.1	215.5	3.1%	(571.0)	-7.6%
Экспорт	3,576.3	2,703.2	2,871.6	873.1	32.3%	(168.3)	-5.9%
Импорт	3,599.3	4,256.9	4,659.5	(657.6)	-15.4%	(402.7)	-8.6%
Тэнцэл	(23.0)	(1,553.6)	(1,788.0)	1,530.7	-98.5%	234.3	-13.1%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсаар дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсаар дунджаар/



Бүтэц: 87% + 13%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсч нийт экспортын 87%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн худэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлоо 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 89%, нийт экспортын 77%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 3.7 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 3.6 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өсөлт: +32.3%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 32.3%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 28.8%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 44%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс, төмрийн худэр болон цайрын баяжмалын экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалzan 15%, 35%, 5%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 11%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 932.7 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 59.6 сая ам.доллараар буурснаар нийтдээ 873.1 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 774 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн худэр, цайрын экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулуун нүүрс, төмрийн худрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 464 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үнэ, бусад экспортын бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалzan 36.4 болон 59.4 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 8 дугаар сарын 29-ний байдлаар унц тутамд 1,287.3-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 7.7%-иар, өмнөх сараас 0.4%-иар тус тус буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн худрийн (CFR Tianjin) үнэ 2014 оны 8 дугаар сарын 29-ний байдлаар 7,008.5, 87.9 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 1.8%-иар, төмрийн худэр 7.7%-иар, өмнөх жилийн мөн үеэс зэс 1.0%-иар, төмрийн худэр 36.2%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо хэмжээ (Мян.тн.кг)	Дүн	%	Тоо хэмжээ (Мян.тн.кг)	Дүн	%	Дүн	%	%2
1. Ашигт малтмал	3,126	87%		2,348	87%		777	33%	28.8%
Чулуун нүүрс	12,225	588	16%	9,593	693	26%	(105)	-15%	-4%
Зэсийн баяжмал	844	1450	41%	395	563	21%	887	158%	38%
Төмрийн худэр/баяж.	3,761	289	8%	4,327	442	16%	(153)	-35%	-7%
Боловсруулаагүй нефть	4,441	443	12%	3,052	298	11%	146	49%	6%
Цайрын худэр ба баяж.	69	76	2%	86	80	3%	(4)	-5%	0%
Мөнгөжөвгүй алт	5,126	214	6%	4,727	95	7%	19	10%	1%
Жонцшлэгц, нефелинг	207	47	1%	221	56	2%	(10)	-17%	0%
Молидбений худэр/баяж	2	18	1%	3	21	1%	(3)	-13%	0%
2. Ноос, ноолуур	247.0	7%		210.6	8%		36	17%	1%
Ямааны угаалга ноолуур	3,834	213	6%	3,915	181	7%	32.2	18%	15%
Ямааны самноолуур	347	34	1%	309	30	1%	4.2	14%	2%
3. Бусад	204	6%		144	5%		59	41%	2%
Нийт дүн	3,576			2,703			873.1	32.3%	

%2 - Өсөлтөд оруулсан нэгжийн нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт	%(%)	Үнийн өөрчлөлт	%(%)	Нийт өөрчлөлт		%(%)
					Тоо хэмжээний өөрчлөлт	Нийт өөрчлөлт	
1. Ашигт малтмал	899		(122)		777		
Чулуун нүүрс	190	-18.1%	(295)	28.1%	(105)	-15%	
Зэсийн баяжмал	639	72%	249	28%	887	158%	
Төмрийн худэр ба баяжмал	(58)	38%	(95)	62%	(153)	-35%	
Боловсруулаагүй нефть	135	93%	10	7%	146	49%	
Цайрын худэр ба баяжмал	(16)	396%	12	-296%	(4)	-5%	
Мөнгөжөвгүй алт	16	87%	2	13%	19	10%	
Жонцшлэгц, нефелинг	(4)	37%	(6)	63%	(10)	-17%	
Молидбений худэр ба баяжмал	(4)	143%	1	-43%	(3)	-13%	
2. Ноос, ноолуур	(0.1)		36.5		36.4		
Ямааны угаалга ноолуур	(3.7)	-12%	35.9	112%	32.2	18%	
Ямааны самнаасан ноолуур	3.6	85%	0.6	15%	4.2	14%	
3. Бусад	34	56%	26	44%	59	41%	
Нийт	932.7		(59.6)		873.1		

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 26% + 42% +21%

Эхний 8 сарын байдлаар нийт импортын 26%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 42%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 21%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортоод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар өссөн бол хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний хувийн жин 6%-иар буурч, нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хадгалагсан байна.

Өсөлт: -15.4%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 12%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 2%-ийг тус тус тайлбарлаж байна. Эхний 3 сарын байдлаар нефтийн импорт нийт импортын бууралтын 8%-ийг тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн нефтийн импорт өссөнөөр уг үзүүлэлт 2% болж буурсан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 26%-иар буюу 519 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 12%-иар буюу 102 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 15.4%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 9%-иар буюу 86 сая ам.доллараар буурахад удаан здэлгээтэй барааны импорт, ялангуяа суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 24%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөргөг тэмдэгтэй 16%-д хүрч буурсан /Дүрслэл 7/. Түргэн здэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны эхнээс эхлэн тогтмол түвшинд байсан бол 7 сараас эхлэн буурах хандлагатай болсон. Харин удаан здэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны 8 сараас эхлэн тогтмол буурч байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизмын тоног төхөөрөмж, түүний эд анги 41%-иар буюу 556 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин барилгын материалын импорт өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар буюу 50 сая ам.доллараар өсчээ.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 11%-иар буюу 41 сая ам.доллараар өссөн нь ерөнхий ангиллуудын хувьд өсөлттэй гарсан ганц бүлэг болж байна. Энэ нь цахилгаан эрчим хүчиний импортын өсөлтөөр голлон тодорхойлогдож байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчиний импорт огцом нэмэгдсэн.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 12%-иар буюу 102 сая ам.доллараар буурчээ. Дүрслэл 8-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны төгсгөлөөс эхлэн буцаад буурч байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2014		2013		Өөрчлөлт			
	Дун	%	Дун	%	Дун	Хувь	Хувь2*	
Хэрэглээний бүтээгдэхүүн	918	26%	1004	24%	(86)	-9%	-2%	
Түргэн здэлгээтэй	486	14%	490	12%	(4)	-1%	0%	
Хүнс	337	9%	348	8%	(12)	-3%	-1%	
Эм, тариа	51	1%	50	1%	1	2%	0%	
Бусад түргэн здэлгээтэй бараа	99	3%	92	2%	7	7%	1%	
Удаан здэлгээтэй	432	12%	514	12%	(82)	-16%	-8%	
Гутал, хүчээс, цунх	38	1%	33	1%	5	14%	0%	
Гэр ахуйн цах.xэрэсэл ба тавилга	86	2%	95	2%	(9)	-9%	-1%	
Авто машин, түүний сэлбэг хөргөсэл	259	7%	341	8%	(81)	-24%	-8%	
Бусад юдаан здэлгээтэй бараа	49	1%	46	1%	4	9%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1503	42%	2022	48%	(519)	-26%	-12%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	791	22%	1347	32%	(556)	-41%	-27%	
Сүйлэлэс бусад тээврийн хөргөсэл, эд анги	203	6%	485	11%	(282)	-58%	-14%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	588	16%	862	20%	(274)	-32%	-14%	
Барилгын материалы	557	15%	508	12%	50	10%	2%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	155	4%	168	4%	(13)	-8%	-1%	
Аж үйлдвэрлэлийн орц	415	12%	374	9%	41	11%	1%	
Хүнсний орц	25	1%	13	0%	11	84%	3%	
Химийн бүтээгдэхүүн	63	2%	66	2%	(3)	-4%	-1%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	10	0%	14	0%	(4)	-30%	-1%	
Цахилгаан эрчим хүч	104	3%	56	1%	48	85%	13%	
Металлын худар, баялжам болон хаягдал	0	0%	0	0%	0	69%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	213	6%	224	5%	(11)	-5%	-3%	
Нефтийн бүтээгдэхүүн	752	21%	853	20%	(102)	-12%	-2%	
Дизель тунци	421	12%	506	12%	(85)	-17%	-10%	
АИ-92, АИ-95	214	6%	197	5%	17	9%	2%	
А-80 болон бусад	117	3%	151	4%	(33)	-22%	-4%	
Бусад	11	0%	3	0%	8	325%	0%	
Нийт дун	3.599		4.257		(658)	-15%		

*2% - Ерөнхий бууралтын зориулалтад оруулсан хувь намэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

